

Солонгос хэлний үндсэн дуудлага ба хэлний бодит байдал

И Жинху

Женнам их сургууль, эх хэл бичгийн тэнхмийн профессор

1. Оршил

Эх хэлний дуудлага нь олон янзаар хувьсан өөрчлөгдөж байдаг. Бүс нутгаас хамаарч эгшгийн тоо өөр байх юмуу ижил бүс нутаг байсан ч нэг үгийн дуудлага ялгаатай байх тохиолдол их байдаг. Тухайлбал, ‘쇠’ гэдэг үгийн дуудлагыг судлаж үзвэл, ‘ㅅ’-ийг тэмдэглэснээр нь [ㅅ]-ээр дууддаг хүн байх боловч [ㅆ]-ээр дууддаг хүн ч бий. ‘쇠’-ийн ‘ㅅ’-ийн дуудлага нь илүү олон янз болохоор дан эгшиг [ㅅ], хос эгшиг [ㅆ], дан эгшиг [ㅈ]-ээр бүгдээр нь дуудах тохиолдол байна.¹ Тиймээс ‘쇠’-ийн бодит дуудлага нь [ㅅ], [ㅆ], [ㅈ], [ㅊ], [ㅊ], [ㅊ], [ㅊ], [ㅊ] зэрэг маш олон янзаар илэрнэ.

Үүнтэй адилаар нэг хэлбэрийн дуудлага олон янзаар илрэн гарч буй жишээг олон харж болно. Ийм тохиолдолд дуудлагын өөр хэлбэр дундаас аль нэгийг нь үндсэн болон суурь дуудлагаар тогтоох болдог. Үүнийг ерөнхийдөө “Үндсэн дуудлага” гэж нэрлэнэ. Эх хэлэнд үндсэн дуудлагыг дүрэм болгож оруулсан тусгай хэлний дүрэм болох <Үндсэн дуудахзүй>-н дүрэм гэж бий. Үүнд эх хэлний үндсэн дуудлага нь төв аялгууны бодит дуудлагыг дагаж, уламжлал ба оновчтой байдлыг бодож үзэж тогтоодог байна.

‘쇠’-ийн үндсэн дуудлага нь [ㅅ] боловч [ㅆ]-г ч бас зөвшөөрнө. Үгийн эхэнд орсон ‘ㅅ’-ийг тэмдэглэснээр нь дуудах дүрэмтэй. Дан эгшиг ‘ㅅ’ нь дан эгшгээр дуудах дүрэмтэй ч бодитоор хос эгшиг ‘ㅆ’-ээр дууддаг хүн их болохоор хос эгшгээр дуудагдахыг зөвшөөрдөг. Үүнтэй адилаар үндсэн дуудлага нь тэмдэглэгээнд суурилж, бодит дуудлагыг сайн харгалзан үзэж тогтоосон байдаг.

Заримдаа бодит дуудлагаас ялгаатай зүйлийг үндсэн дуудлагаар тогтоосон байх нь ч бий. Тухайлбал, ‘한빛’ гэдэг нэртэй хүнийг дуудахдаа ‘한빛아’-ийн дуудлагыг хүмүүсээс асууж үзвэл олонхи хүмүүс [한비다] бас [한비사] гэж хариулна. Гэхдээ үндсэн дуудлага нь [한비차] юм. Эх хэлэнд эгшгээр эхэлсэн нэрийн нөхцөл залгавал өмнөх үгийн дэвсгэр үсэг нь тэр чигээрээ хойд талын үеийн эхний авиагаар дуудагдах ёстой гэсэн дүрэм бий.² Үүнээс шалтгаалаад ‘한빛’ дээр нэрийн нөхцөл ‘아’-г залгасан ‘한빛아’ нь [한비차] гэж дуудах нь зөв юм.

<Үндсэн дуудахзүй>-д гийгүүлэгч ба эгшгийн жагсаалт, үндсэн дуудлага, гол дуудлагын зарчим зэргийг тогтоосон байдаг. Мөн эх хэлний толь бичигт тус бүрийн толгой бүрт дуудлагын тэмдэглэгээ орсон байдаг. Тиймээс <Үндсэн дуудахзүй> ба эх хэлний толь бичгээс л хайхад үндсэн дуудлага юу болохыг хялбар нягталж болно. Гэхдээ олонхи хүмүүст үндсэн дуудлага юмуу <Үндсэн дуудахзүй> нь анхаарал хандуулах зүйл биш юм. Дуудлагыг хэрхэн дуудах нь хамаагүй хэл нэвтрэлцвэл болох бишүү гэсэн бодолтой хүмүүс анхаарал хандуулахгүй байх бөгөөд өөрийнх нь дуудлага үндсэн дуудлага биш гэсэн таагүй сэтгэгдэлтэй хүмүүс сэтгэл хангалуун бус байдлыг илэрхийлдэг. Үндсэн ба бодит дуудлагын ялгаанаас бий болох үл зөвшөөрөх байдал нь багагүй гэж бодож байна.

Уг өгүүлэлд үндсэн ба бодит дуудлага нь ямар ялгаатай, эдгээр нь ямар үзэгдэлтэй холбоотойг ажиглаж үзэх болно. Үүний тулд 2-р хэсэгт эхлээд одоо хэрэгжиж буй <Үндсэн дуудахзүй>-н талаар нарийвчилан ажиглаж судлана. 3-р хэсэгт <Үндсэн

¹. Олон хүмүүс ‘ㅆ’ ба ‘ㅈ’-г ялгаж чаддаггүй учраас хос эгшиг ‘ㅆ’ юмуу дан эгшиг ‘ㅆ’ нь ч бас бодитоор олон өөр хэлбэртэй.

². Энэ зарчмыг ‘Ухарч дуудагдах(連音)’ гэж нэрлэдэг. Ухарч дуудагдах зарчим нь гийгүүлэгчээр төгссөн үгийн араас эгшгээр эхэлсэн бүтээвэр нэрийн нөхцөл юмуу үйлийн нөхцөл, дагавар залгах үед хэрэгжинэ.

дуудахзүй>-д дүрэм болгож оруулсан үндсэн дуудлага нь бодит дуудлагаас хэрхэн өөр байгааг нарийвчилсан жишээгээр гаргаж ирнэ. 4-р хэсэгт бодит дуудлагын улмаас илэрч буй тэмдэглэгээний асуудлыг судлах болно.

2. Эх хэлний <Үндсэн дуудахзүй>

Эх хэлний үндсэн дуудлагыг төв аялгууны дүрмийн 2-р хэсэг болох <Үндсэн дуудахзүй>-д тогтоосон байдаг. <Үндсэн дуудахзүй> нь нийт 7 бүлэг 30 зүйлээр, тодорхой үндсэн дуудлагыг агуулсан байдаг. Олон улсад үндсэн дуудлагын хэрэгцээтэй байдлыг хүлээн зөвшөөрч түүнээс шалтгаалж үндсэн дуудлагыг тогтоосон байдаг боловч, эх хэл шиг бичмэлжүүлэх дүрмээр <Үндсэн дуудахзүй>-г тогтоосон улс бараг байхгүй. Хэлний бодлогын талаар удаан хугацааны уламжлал, түүхтэй Франц юмуу Герман зэрэг улсууд хүртэл <Үндсэн дуудахзүй> нь тусдаа байхгүй бөгөөд жүжгийн тайзны дуудлага юмуу эх хэлний толь бичигт бичигдсэн дуудлагын тэмдэглэгээ зэргийг үндсэн дуудлагаар тогтоосон байдаг. Европт нэвтрүүлгийн хэлний дуудлагыг төв аялгуу гэж үздэг.

Эх хэлний <Үндсэн дуудахзүй>-ээс гадна Хойд Солонгосын <Соёлын хэлний дуудахзүй> ба Хятадын зүүн хойд 3 мужийн <Жүсөн хэлний үндсэн дуудахзүй> зэргийг үндсэн дуудахзүй гэж үзэж болно. Уг 2 жишээ хоёулаа гадаад жишээ боловч бүгд эх хэлтэй ижил хэлийг объект болгосон юм. Хойд солонгост 1950 оноос <Жүсөн хэлний зөв бичихзүй>-н нэг хэсэг болгож үндсэн дуудахзүйг тогтоосон бөгөөд 1960 онд орж ирснээр үүнийг бие даасан хэлний дүрэм болгосон. Мөн 1980 онд <Соёлын хэлний дуудахзүй> болгож нэрийг нь өөрчилсөн. Хятадын зүүн хойд 3 мужийн <Жүсөн хэлний үндсэн дуудахзүй>-г 1970 онд зохиож, 1999 онд <Жүсөн хэлний үндсэн дуудлагын толь бичиг> хүртэл хэвлэгдэн гарсан. Гэхдээ энэ дүрэм нь 1960 онд тогтоосон Хойд Солонгосын үндсэн дуудахзүйн дүрэмд тулгуурласан учраас их ялгаа байхгүй.³

Эх хэлний <Үндсэн дуудахзүй>-г 1988 онд зарлаж 1989 оноос хэрэгжиж эхэлсэн учраас Хойд Солонгос юмуу Хятадын Зүүн хойд 3 мужтай харьцуулахад богино түүхтэй гэж хэлж болно. Гэхдээ угтаа бол <Үндсэн дуудахзүй>-г тогтоох гэсэн оролдлого нь 1968 оноос эхэлсэн. Ингээд 1970-аад оны дундуур эхний загвар төсөл гарч, 1970 оны сүүлээр шинэчлэх төсөл гарч байсан. Гэхдээ үүнээс хойш ард түмний эсэргүүцэл буюу улс төрийн нөхцөл байдлын улмаас шийдэж чадаагүй бөгөөд үүн дээр <Үндсэн дуудахзүй>-г зохиох байгууллага хүртэл өөрчлөгдөж, үүнийг зарлах хүртлээ ойролцоогоор 20 жил орчим зарцуулсан.

Үүнтэй адилаар удаан хугацаанд <Үндсэн дуудахзүй>-г тогтоох явцад <Үндсэн дуудахзүй>-н шинж чанар нь ч бас маш их өөрчлөгдсөн. Эхэн үедээ хатуу авиа ба урт авианы асуудалд хамгийн их анхаарал хандуулж байсан. Тухайн үед ямар нэгэн авиаг хатуу авиагаар дуудах уу, урт авиагаар дуудах уу, богино авиагаар дуудах уу гэдэг асуудлыг хамгийн маргаантай асуудал гэж үзэж, уг 2 хэсгийг голлож, бусад хэсгийг ч бас хамт дурдсан байсан. Иймэрхүү эхэн үеийн арга нь үг тус бүрт голлож, маргаантай дуудлагыг цэгцлэхэд гол анхаарлаа хандуулж байсан.

Гэхдээ сүүлд гарсан <Үндсэн дуудахзүй>-н агуулга нь эхэн үеийнхээс маш их өөрчлөгдсөн. Үг тус бүрийн маргаантай дуудлагыг цэгцлэхээс илүү эх хэлний дуудлагыг нийтээр нь тогтоож, таамагласан боломжит дүрмийн дуудлага юу болохыг тодорхой тайлбарлах аргыг сонгосон байна. Ингэж эхний үеийн <Үндсэн дуудахзүй> нь үг тус бүрийн үндсэн дуудлагыг цуглуулсан “Материалын цуврал”-ын хэлбэр байсан бол хамгийн эцсийн <Үндсэн дуудахзүй> нь эх хэлний дуудлагын гол зарчмыг агуулсан “Дүрмийн цуврал”-ын хэлбэр болсон.

Тэглээ гээд <Үндсэн дуудахзүй>-д эх хэлний дуудлагын зарчим мөн дуудлагын үзэгдэл бүгд орсон гэсэн үг биш юм. Одоо мөрдөж буй <Үндсэн дуудахзүй>-н шинж чанарыг нарийвчлан хураангуйлбал тэмдэглэгээ ба дуудлага нь тохирохгүй байх

³. Хойд Солонгосын <Соёлын хэлний дуудахзүй> ба Хятадын зүүн хойд 3 мужийн <Жүсөн хэлний үндсэн дуудахзүй>-н талаар И Жинху (2012) судласан байна.

тохиолдолд үндэслэн үндсэн дуудлагыг тогтоосон гэж хэлж болно. Тэмдэглэгээ ба дуудлага нь тохирч байх тохиолдолд <Үндсэн дуудахзүй>-д юу ч дурдаагүй байна. <Хангыл үсгийн зөв бичихзүй>-д хэдэн гол авианы үзэгдлийн тохиолдолд тэр чигээр нь тэмдэглэх дүрэмтэй ч ийм жишээнүүд нь <Үндсэн дуудахзүй>-д гарч ирээгүй учраас <Үндсэн дуудахзүй> нь эх хэлний дуудлагын бүх талыг нь хамруулж чадаагүй.

Жишээлбэл, хувирдаг үгийн язгуурын сүүлийн гийгүүлэгч гээгдэх үзэгдэл ч <Үндсэн дуудахзүй>-д зарим нь гараад, зарим нь гараагүй байдаг. ‘아는[아:는](알+는)’, ‘사는[사:는](살+는)’ зэргээс харж байгаагаар ‘ㄷ’-ээр төгссөн бүх хувирдаг үгийн язгуур нь ‘ㄴ’-ээр эхэлсэн үйлийн нөхцлийн өмнө ‘ㄷ’ нь гээгдэж, ‘낳은[나은], 낳으니[나으니]’-д харж байгаагаар ‘ㅎ’-ээр төгссөн бүх хувирдаг үгийн язгуур нь эгшгээр эхэлсэн нөхцөл юмуу дагаврын өмнө ‘ㅎ’ нь гээгдэнэ. Ийм 2 төрлийн гээгдэх үзэгдэл нь зайлшгүй гарах боловч ‘ㄷ’ гээгдэх үзэгдэл нь <Үндсэн дуудахзүй>-д гарч ирэлгүй ‘ㅎ’ гээгдэх үзэгдэл л <Үндсэн дуудахзүй>-д гарсан байдаг. Түүний учир нь энгийн юм. ‘ㄷ’ гээгдэх үзэгдэл нь тэмдэглэгээнд тусгалаа олж, ‘ㅎ’ гээгдэх үзэгдэл нь тэмдэглэгээнд тусгалаа олдоогүй учраас юм.

Тэмдэглэгээ ба дуудлага нь тохирохгүй байх тохиолдлыг л <Үндсэн дуудахзүй>-д оруулсан болохоор <Үндсэн дуудахзүй> нь эх хэлний бүх дуудлагыг бүрэн гүйцэд тогтоож чадаагүй нь үнэн юм. Гэвч энэ нь яах ч аргагүй зүйл юм. <Үндсэн дуудахзүй> нь сургалтын хувьд эх хэлний дуудлагыг бүгдийг нь тогтоох ёстой гэсэн үг биш юм. Харин эх хэлний авиазүй гэсэн салбарт оруулахад болох юм. Тэмдэглэснээр нь дуудахад болох тохиолдлыг хүртэл хамруулж, агуулгыг будлиантай болгох хэрэг байхгүй юм. Үг тус бүрийн дуудлагыг мэдэхийг хүсвэл эх хэлний толь бичгээс хайж, тэмдэглэгээ ба дуудлага тохирохгүй байх тохиолдлын дуудлагын зарчмыг мэдэхийг хүсвэл <Үндсэн дуудахзүй>-ээс хайх ба эх хэлний дуудлагын ерөнхий үндэс ба зарчим зэргийг мэдэхийг хүсвэл эх хэлний авиазүйтэй холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хайхад болох юм.

3. Үндсэн дуудлага ба бодит дуудлагын ялгаа

<Үндсэн дуудахзүй>-д дүрэм болгож оруулсан үндсэн дуудлага нь төв аялгууны бодит дуудлагад суурилсан боловч энэ хоёрын хооронд багагүй ялгаа бий. Иймэрхүү ялгаа гарч байгаа чухал шалтгааны нэг нь <Үндсэн дуудахзүй>-д үндсэн дуудлагын материал нь ерөнхийдөө 1980-аад оны тухайн үед Сөүлийн уугуул аялгууг хэрэглэдэг ахмад үеийн хэлэлцэгчдийн дуудлага байсан нь юм. Сөүлд амьдарч төв аялгуунд ойрхон хэлийг хэрэглэж байгаа гэж итгэдэг хүмүүсийн дунд ч цаг үеэрээ ба төрсөн газраараа ялгаатай дуудлагатай байдаг. Тиймээс <Үндсэн дуудахзүй>-г тогтоосон тухайн үед ч <Үндсэн дуудахзүй> ба бодит дуудлага нь ялгаатай байсан бөгөөд түүнээс хойш ойролцоогоор нэг үед хамаарах цаг хугацаа өнгөрсөн одоо цагт энэ хоёрын ялгаа их байхаас өөр аргагүй.

Үндсэн дуудлага ба бодит дуудлагын ялгаа нь олон талаар илрэх бөгөөд үүн дундаас төлөөлөл болох хэдэн жишээг ажиглаж үзье. Эхлээд хамгийн тодорхой болсон ялгааг дан эгшиг (單母音)-ийн тооноос харж болно. Үндсэн дуудлагад дан эгшгийн тоо нь 10 эгшиг (ㅏ, ㅑ, ㅓ, ㅕ, ㅗ, ㅛ, ㅜ, ㅠ, ㅡ, ㅣ) юм. Ийм 10 дан эгшиг нь 1980 оны үеийг суурь болговол Кёнги аймаг, Канвөн аймаг, Чүнчөн өмнөд, хойд аймаг, Желла хойд аймаг, Жөннам Зүүн хойд хэсгийн ахмад үеийнхний хэлэнд илэрч байдаг. Гэхдээ тухайн цаг үед ч ‘ㅓ, ㅕ’ нь дан эгшгээс байр нь хөдөлж, хос эгшгээр дуудах тохиолдол их байсан. Ийм дуудлагын бодит байдлыг харгалзан үзэж ‘ㅓ, ㅕ’ нь хос эгшгээр дуудахыг зөвшөөрсөн.

Гэвч одоо дунд насны давхаргаас доош үеийн олонхи хүмүүс 7 дан эгшгийг л дуудаж байна. Энэ нь <Үндсэн дуудахзүй>-д хүлээн зөвшөөрдсөн 8 дан эгшиг дунд ‘ㅓ’ ба ‘ㅕ’-г

ялгаж чадахгүй байгаагийн үр дүн юм.⁴ Одоо ‘니, 기’-г дан эгшгээр дуудах юмуу ‘히’ ба ‘네’-г ялгаж дуудаж чадах өгүүлэгч нь нийт ард түмний дунд маш цөөн ахмад насныхан байна. Нэвтрүүлэгчдийн дуудлагад ч эгшгийг <Үндсэн дуудахзүй>-г сахиж дуудах тохиолдлыг олоход хэцүү. Энэ мэт шалтгаанаар цаг хугацаа бага зэрэг өнгөрөхөд <Үндсэн дуудахзүй>-д дүрэм болгож оруулсан дан эгшгийг бүрэн зөв дууддаг солонгос хүнтэй уулзаж чадахгүй ч байж мэдэх юм.

Хос эгшгийн дуудлага ч бас үндсэн ба бодит дуудлага нь ялгаатай бөгөөд ялангуяа ‘니’-ийн дуудлага бол гол жишээ юм. ‘니’-ийн бодит дуудлага нь асар олон янз учраас <Үндсэн дуудахзүй>-д ч олон зүйлээр тайлбарласан байдаг. Үгийн эхэнд орсон ‘의’ ба ‘히다, 찍어’ зэрэг ‘니’-ийн өмнө гийгүүлэгч байгаа тохиолдолд ‘니’ нь [니] ба [] болж тус тус дуудагдах ёстой. Түүнээс гадна бодит дуудлагыг бодож үзэж [니] –ээс бусад дуудлагыг ч бас хүлээн зөвшөөрдөг. Гэвч бодит дуудлага нь үндсэн дуудлагаас хол ялгаатай байдаг. Жишээлбэл, ‘의의’ гэсэн үгийн үндсэн дуудлагын зарчим нь [의의] бөгөөд [의이] –ийг ч зөвшөөрдөг боловч бодит дуудлагад [으이]-аар ихэнхи тохиолдолд дууддаг. Мөн ‘주의(主義), 협의(協議)’ зэрэг үгс ч <Үндсэн дуудахзүй>-н зарчим болох [주의], [협비] зэргээр бараг гарахгүй бөгөөд [주이], [협비] –ийг л хэрэглэдэг байна.

Гийгүүлэгчийн хувьд голдуу давхар дэвсгэр үсгийн дуудлагад үндсэн ба бодит дуудлагын ялгаа гарч ирдэг. Жишээлбэл, ‘뵈고, 뵈다, 워다’ зэрэг давхар дэвсгэр үсэгтэй үгс нь тэмдэглэгээндээ дэвсгэрт 2 гийгүүлэгч байдаг боловч дуудлагын хувьд давхар дэвсгэр үсэг дундаас аль нэгийг нь дуудах ёстой. Энэ нь эх хэлний үеийн төгсгөлд 2 гийгүүлэгчийг хоёуланг нь дуудаж болохгүй гэсэн гол зарчмыг баримтласан учраас юм. Тиймээс <Үндсэн дуудахзүй>-д давхар дэвсгэр үсгийн ангилал ба үгээс нь хамаараад давхар дэвсгэр үсэг дундаас аль гийгүүлэгчийг гээх талаар зааж оруулсан байдаг. Түүнд үндэслэвэл ‘뵈고’ нь [뵈:꼬], ‘뵈다’ нь [뵈따], ‘워다’ нь [워따] гэж дуудагдах ёстой.

Харин бодит дуудлагад ингэж дуудаагүй тохиолдлыг олон харж болно. Давхар дэвсгэр үсгийг дуудах үед <Үндсэн дуудахзүй>-н дүрмийг тогтоосон тэр чигээр нь зөв дууддаг хүн хэчнээн байгааг бодох хэмжээнд давхар дэвсгэр үсгийн дуудлагыг асар олон янзаар дууддаг.⁵ Үүний улмаас эх хэлний шалгалтад давхар дэвсгэр үсгийн үндсэн дуудлага нь юу болохыг асуусан асуулт байнга гардаг. Шалгалтын материал зохиогчийн байр суурьнаас хүмүүс их алддаг зүйл учраас оруулсан гэж бодож болох ч шалгалт өгч байгаа хүний байр суурьнаас <Үндсэн дуудахзүй>-г системтэйгээр цээжлээгүй бол хариулж чадахгүй асуулт учраас <Үндсэн дуудахзүй>-н талаар дургүйцэх тохиолдол байдаг байна.⁶

Гийгүүлэгч авиа ижилсэх үзэгдэлд ч үндсэн ба бодит дуудлага нь ялгаатай байх тохиолдол байдаг. Төлөөлөл болгож ‘(가기) 싫니?’ зэрэг ‘ㄹㅎ’-аар төгссөн хувирдаг үгийн язгуурын араас асуух хэлбэрийг илэрхийлэх өгүүлбэр төгсгөх нөхцөл ‘-니’ –ийг залгаж буй тохиолдлыг дурдаж болно. <Үндсэн дуудахзүй>-д ‘싫니’ нь [실리]-ээр дуудах ёстой. Энэ нь ‘끓는, 닳는’-ийг [끓른] ба [달른] гэж тус тус дуудаж байгаагаар адил гийгүүлэгч авиа ижилсэх ёс илэрч байгаа учраас юм. Гэхдээ ‘싫니?’-ийг [실리]-ээр дуудах тохиолдол бараг байхгүй. Ер нь бол ‘싫니’ –ийн оронд ‘싫으니[시르니]’ гэж дуудвал энэ нь буруу юм. Асуух хэлбэрийн төгсгөх нөхцөл нь ‘떡니?, 잡니?’ зэргээс харж байгаачлан хэлбэр нь ‘-니’ бөгөөд ‘-으니’ биш учраас юм.⁷ Хүмүүс [실리] зэрэг үндсэн дуудлага нь эвгүй болохоор хэрэггүй ‘으’-г илүү нэмж [시르니] гэж дууддаг байна.

⁴. Үүний улмаас өдөр тутмын амьдралд ‘히’ ба ‘네’-г ялгах хэрэгтэй тохиолдол гарвал ‘히’ нь ‘아이’, ‘네’ нь ‘어이’ гэж дуудах тохиолдол асар их байдаг.

⁵. Үүнийг сайн харуулж буй жишээ нь ‘뵈고’-ийн үндсэн дуудлага юм. <Үндсэн дуудахзүй>-г тогтоох явцад эхэндээ ‘뵈고’-ийн үндсэн дуудлагыг [뵈 : 꼬] гэж байгаад сүүлд [뵈 : 꼬] гэж зассан юм.

⁶. Сүүлийн үед олон төрлийн эх хэлний шалгалтад хэлний дүрэм, хэлзүйтэй холбоотой асуултууд багагүй гарч байна. Гэхдээ мэдлэгийг системтэйгээр цээжилж байж хариулж болох зүйлс их болохоор эсрэгээрээ хэлний дүрэм ба хэлзүйн талаар дургүйцлийг бий болгох тохиолдол их байдаг байна.

⁷. ‘뵈을 먹으니 배가 부르다.’ –тай адил учир шалтгаан илэрхийлэх холбох нөхцөл нь ‘-으니’ боловч энэ нь асуух хэлбэрийн төгсгөх нөхцөлөөс өөр үйлийн нөхцөл юм.

Дээрх жишээнүүдээс харахад үндсэн ба бодит дуудлага нь өөр хэлбэрээр илэрч байгаа жишээ маш их байна. Ийм ялгааны улмаас зарим хүмүүс <Үндсэн дуудахзүй>-н дүрэм нь буруу болсон гэж санал дэвшүүлэх нь ч бий. Гэвч уг саналыг хүлээн авахад хэцүү юм. Аль ч улсын хэлэнд хэлний дүрэм бодит байдалтай бүрэн тохирдог тохиолдол байхгүй. Хэлний дүрэм нь хэлний өөрчлөлтийн хурдыг дагаж чаддаггүй байна. Хэл хувьсан өөрчлөгдөж байгаагаар хэлний дүрмийг өөрчлөнө гэвэл том будлиан бий болно. Өмнө нь дурдсанчлан <Үндсэн дуудахзүй>-н дүрмийг тогтоосон 1980 онд ч төв аялгуунд аль хэдийнэ авианы өөрчлөлт байсан. Тухайн цаг үед ч аль хэдийнэ үндсэн ба бодит дуудлага нь өөр байсан бөгөөд ийм ялгаа нь цаг хугацааны урсгал ба өөрчлөлтөөс шалтгаалж хуримтлагдаж ихсэхээс өөр арга байхгүй юм. Ийм үйл явцыг тооцож үзвэл дан ганц хэлний бодит байдал ба дүрмийн агуулга нь тохирохгүй байна гэсэн шалтгаанаар л шүүмжлэх нь тохиромжтой хандлага гэж үзэж болохгүй.⁸

4. Дуудлага ба тэмдэглэгээний алдаа

Дуудлага нь Хангыл үгсийн тэмдэглэгээтэй нягт холбоотой байдаг. <Хангыл үгсийн зөв бичих дүрэм>-д төв аялгууг дуудлагаар бичээд хэлний дүрэмд тааруулна гэж тогтоосон байдаг. Тиймээс хэлний дүрэмд тааруулж бичих тохиолдол биш бол дуудлагаар нь бичихэд болно. Энэ үеийн дуудлага нь мэдээж үндсэн дуудлагыг илтгэнэ. Үүнд үндэслэн үндсэн дуудлагад зөвшөөрөөгүй бодит дуудлагыг тэр чигээр нь тэмдэглэвэл алдаа болно. Үнэн бодит байдалд ийм жишээ байнга гарч байдаг. Хүмүүсийн байнга гаргадаг тэмдэглэгээний алдаа нь ерөнхийдөө дуудлагаас эхэлдэг тохиолдол их байдаг.

Зоогийн газрын хоолны цэсийг харвал ‘찌개’ гэж бичих ёстой үгийг ‘찌개’ гэж бичсэн тохиолдол багагүй байдаг. ‘ㅈ’-г ‘ㅉ’-ээр буруу бичсэн байдаг. Эсрэгээрээ ‘사래’-г ‘샤래’-ээр бичдэг шиг ‘ㅈ’-г ‘ㅉ’-ээр буруу бичсэн тохиолдол ч их байдаг. Үүнтэй адилаар ‘ㅈ’ ба ‘ㅉ’-г тодорхой ялгаж чадалгүй хооронд нь хольж солих нь байнга хэрэглэгддэггүй үг байх тусмаа илүү байдаг байна.

Ийм алдаа нь зөвхөн хувь хүний бичигт гарах биш телевизийн хадмал үг түүгээр ч үл барам албан бичигт хүртэл гардаг.

‘ㅈ’ ба ‘ㅉ’-г хольж буруу бичих нь эх хэлний бодит дуудлагад ‘ㅈ’ ба ‘ㅉ’ нь хоорондоо ялгагдахгүй байгаатай шууд холбоотой. Өмнө нь дурдсанчлан <Үндсэн дуудахзүй>-д ‘ㅈ’ ба ‘ㅉ’-г тусдаа дан эгшиг гэсэн байдаг боловч энэ 2 эгшиг нь аль хэдийнэ олонхи хүмүүсийн дуудлагад ялгагддаггүй байна. Тиймээс харж, тодорхой тогтоосон үг биш л бол ‘ㅈ’ нь зөв үү ‘ㅉ’ нь зөв үү гэдгийг андуурч болно. Ийм хүндрэл нь гадаад хүнд солонгос хэл заах үед ч зайлшгүй гарч ирнэ. Солонгос хэл заадаг багш нар ч ялгаж чадахгүй байх бөгөөд дан эгшгийг тэмдэглэгээнд нэг бүрчлэн ялгаж зааж өгдөг учраас гадаад хүний байр суурьнаас бүгдийг нь цээжлэхээс өөр аргагүй.

‘ㅈ’ ба ‘ㅉ’-ийн ялгаатай холбоотой өөр нэг жишээ бол ‘되’ ба ‘돼’-ийн тэмдэглэгээний маргаан юм. Телевизийн хадмал үг юмуу зарим төрлийн мэдээллийн хэрэгслээр ‘되서’ гэж бичих ёстойг ‘되서’ гэж бичсэн тохиолдол их байдаг. Үндсэн дуудлагаар гэвэл ‘되서’ ба ‘되서’ нь дуудлага нь ялгагддаг учраас дуудлагаар нь бичсэн ч энэ хоёрыг андуурах шалтгаан байхгүй. Гэхдээ бодит дуудлагад дан эгшиг ‘ㅈ’-г хос эгшиг ‘ㅉ’-ээр дуудах тохиолдол их байдаг бөгөөд цаашлаад ‘ㅈ’ ба ‘ㅉ’-г хүртэл ялгаж чадахгүй ‘되’-ээр

⁸. Зөвхөн <Үндсэн дуудахзүй>-н дотоод уялдаа холбоо нь асуудалтай байвал энэ нь цаашид засах хэрэгтэй зүйл юм. Энгийн жишээ дурдвал давхар дэвсгэр үсэг ‘ㅈ’-ийн дуудлагын талаар <Үндсэн дуудахзүй> 10-р зүйлд үгийн төгсгөл юмуу гийгүүлэгчийн өмнө [ㄷ]-ээр дуудагдах зүйлийг зарчим болгож оруулсан ч 18-р зүйл юмуу 23-р зүйлд [ㅈ]-ээр дуудагдана гэсэн байдаг. Ижил давхар дэвсгэр үсгийн дуудлага нь зүйл заалтаасаа хамаараад өөр байгааг цаашид засах шаардлагатай юм.

бичих юмуу ‘돼’-ээр бичсэн дуудлага нь ижил байх тохиолдол бий.⁹ Тиймээс зөвхөн дуудлагаар ‘되’ ба ‘돼’ –ийн аль нь зөв болохыг мэдэж чадахгүй болдог байна.

Нөгөө талаар харъяалахын тийн ялгалын нөхцөл ‘의’-ийг өгөх оршихын тийн ялгалын нөхцөл ‘에’-ээр буруу бичих тохиолдол ч элбэг байдаг. Жишээлбэл, ‘한국의 명소’-г ‘한국에 명소’ гэж бичих ч юмуу, ‘서울의 야경’-ийг ‘서울에 야경’ гэж бичдэг. Энэ нь хос эгшиг ‘-이’-ийн дуудлагатай холбоотой юм. <Үндсэн дуудахзүй>-д нэрийн нөхцөл ‘의’-ийн талаар [-] гэж дуудах дүрэмтэй ч [이]-ээр дуудахыг ч зөвшөөрдөг. Мөн бодит дуудлагад ихэнхи хүмүүс нэрийн нөхцөл ‘의’-ийг [이]-ээр дууддаг. Үүний улмаас ‘의’ гэж бичих ёстойг ‘에’ гэж буруу бичих тохиолдол байн байн гарна. Эдгээр жишээнүүд бүгд бодит дуудлагын нөлөөг авч бий болсон тэмдэглэгээний алдаанд хамаарна. Гэхдээ ховор боловч үндсэн дуудлагын нөлөөг авч буруу тэмдэглэдэг тохиолдол ч бий. Жишээлбэл, насанд хүрэгчид хүртэл ‘치웃이, 히웅이’ зэргээр бичих ёстой ч ‘치웃이, 히웃이’ зэргээр бичдэг тохиолдол багагүй байдаг. ‘치웃이, 히웅이’ нь угтаа авиа ухарч дуудагдах ёсоор бол [치으치], [히으히] гэж дуудах ёстой боловч <Үндсэн дуудахзүй>-д [치으시], [히으시]-ийг үндсэн дуудлага гэж оруулсан байдаг.¹⁰ Мөн ийм дуудлагаар нь ‘치웃이, 히웃이’ гэж буруу бичдэг үр дагавар ч бий болсон.

Дээрхтэй адилаар дуудлага нь тэмдэглэгээтэй нягт холбоотой байдаг. Тиймээс буруу дуудлага юмуу маргаантай дуудлага байвал тэмдэглэгээний алдаанд хүргэх магадлал их байдаг. Мэдээж ховор боловч үндсэн дуудлагыг дагаад бий болох тэмдэглэгээний алдаа ч үүсч болно. Ямартай ч эх хэлэнд дуудлага ба тэмдэглэгээ нь хоорондоо нягт холбоотой учраас үндсэн дуудлагыг солих нь дан ганц дуудлагын хүрээнд зогсохгүй Хангыл үсгийн зөв бичихзүйтэй холбогдохоос өөр аргагүй юм. Үндсэн дуудлагыг бодит дуудлагад тохируулж засах нь амар биш байх шалтгаан нь ч энэ юм.

5. Дүгнэлт

Уг өгүүлэлд эх хэлний үндсэн ба бодит дуудлагын талаар хэд хэдэн асуудлыг нягтлан гаргаж үзлээ. Бодит дуудлагад илэрч буй олон янзын өөр дуудлага дунд нэгийг нь үндсэн дуудлага болгож тогтоосон бөгөөд ийм үндсэн дуудлага нь бодит дуудлагаас багагүй ялгаатай нь тодорхой юм. Түүнчлэн хэлний амьдралд байнга илэрч байдаг тэмдэглэгээний алдаан дунд дуудлагын нөлөөгөөр үүссэн зүйлс ч нэлээд байгааг мэдэж авсан.

Өнгөрсөн үед хэлний хэрэглээний олон талыг хүлээн зөвшөөрөхөөс илүү аль нэг тал руу нь нэгтгэх гэсэн чиг хандлага хүчтэй байсан. Гэвч цаг хугацаа өнгөрөхөд зохиомлоор нэгтгэсэн чиглэлийн талаар дургүйцэл үүсч, эсрэгээрээ олон талыг хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн дуу хоолой гарч ирэх болсон. Ялангуяа нийгмийн олон ургалч үзэл ба ардчилал хурдацтайгаар бий болсноор ийм хандлага илүү хүчтэй болж ирсэн. Сүүлийн үед орж ирснээр хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар зөвшөөрсөн төв аялгуу нь үргэлж нэмэгдэх нь ч ийм хөдөлгөөнд нөлөөлсөн гэж хэлж болно.

Үндсэн дуудлагын асуудал ч иймэрхүү талыг үл тоомсорловол төвөгтэй болох юм. Ялангуяа үндсэн дуудлага нь хэлний бодит байдлаас хол ялгаатай байгаа тохиолдлыг хэлж болно. Мэдээж үг тус бүрт хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар зөвшөөрсөн төв аялгууг зөвшөөрөх ба <Үндсэн дуудахзүй>-н дүрмийг засч хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар зөвшөөрөх нь ижил зүйл биш юм. Техникийн хувьд ч амар биш бөгөөд маш олон хоёр дуудлагыг үндсэн дуудлагаар зөвшөөрөх тохиолдолд үндсэн дуудлагын оршин тогтнолын талаар эргэлзээг хүртэл бий болгож болно. Гэвч

⁹ . Хос эгшиг болох ‘-이’ ба ‘-이’-ийн ялгаа нь ‘-이’-ийн тохиолдолд ‘-이’-ээр төгсдөг боловч ‘-이’-ийн тохиолдолд ‘-이’-ээр төгсөх нь бий. Тиймээс ‘-이’ ба ‘-이’-г ялгаж чадахгүй хүмүүс ‘-이’ ба ‘-이’-г ч ялгаж чадахгүй. Адилхан шалтгааны улмаас ‘-이’ ба ‘-이’-г ч ялгах аргагүй юм.

¹⁰ . Үүнтэй адил авиа ухарч дуудагдах үзэгдлийн талаарх бусад дүрэм нь ‘키웁이, 피웁이’ зэрэгт ч бас хэрэгжинэ. 1930 онд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бичиг «Хангыл» 7-р ботийн дугаар 8-д ‘키웁이, 피웁이, 히웅이’ зэргийн дуудлагын талаар асуудал урган гарсан удаа бий. Тухайн үед Жусөн хэлний нийгэмлэгээс тус авиаг зөв судлаад дуудаарай гэсэн харилуулыг өгсөн бөгөөд энэ нь ухарч дуудагдах ёс байсан болохоор одооныхоос ялгаатай байсан.

энэ асуудлын талаар оновчтой шийдвэрлэх аргыг хайж эрэлхийлэх хэрэгцээ байна. Тэгж байж сая нэг юм өөрчлөгдөж буй нийгэм ба дуудлагын бодит байдалд тохирох <Үндсэн дуудахзүй>-н дүрмийн зорилгыг хамгаалж болно гэж бодож байна.

Номзүй

- 권인한(2000), 표준발음, 《새국어생활》10 권 3 호, 국립국어연구원, 153~160.
- 김봉국(2008), 음운론적관점에서본‘표준어규정(제 2 부표준발음법)’의문제점, 《열린정신인문학연구》9 권 1 호, 원광대인문학연구소, 151~174.
- 김선철(2004), 표준발음법분석과대안, 《말소리》50, 대한음성학회, 23~39.
- 민현식(1999), 《국어정서법연구》, 태학사.
- 배주채(2003), 《한국어의발음》, 삼경문화사.
- 배주채(2006), 표준발음법의이상, 《어문연구》34 권 3 호, 한국어문교육연구회, 69~92.
- 송철의(1993), 자음의발음, 《새국어생활》3 권 1 호, 국립국어연구원, 3~22.
- 송철의(1998), 표준발음법, 《우리말바로알기》, 문화관광부, 61~81.
- 신승용(2003), 표준발음의실재와표준발음법교육의필요성-중등교육을중심으로-, 《어문연구》31 권 2 호, 한국어문교육연구회, 97~116.
- 신지영(2006), 표준발음법에대한비판적검토, 《한국어학》30, 한국어학회, 133~158.
- 이병근(1988), 표준발음법해설, 《표준어규정해설》, 국어연구소, 45~75.
- 이승재(1993), 모음의발음, 《새국어생활》3 권 1 호, 국립국어연구원, 23~38.
- 이진호(2009), 《국어음운교육변천사》, 박이정.
- 이진호(2012), 《한국어의표준발음과현실발음》, 아카넷.
- 이현복(1989), 《한국어의표준발음》, 교육과학사.
- 이호영(2000), 서울말과표준발음법, 《서울말연구》1, 박이정, 177~203.
- 최명옥(2004), 《국어음운론》, 태학사.
- 최호철(2002), 남북한통일표준발음법시안, 《남북의언어어떻게통일할것인가》, 국학자료원, 101~118.

Сэтгүүлийн нэр: Сэгүгөсәнхуал
Хэвлэгдсэн газар: БНСУ-ын эх хэлний академи
Сэтгүүлийн дугаар: 2015 оны 25-р боть, №1 Хавар
Хуудас: 3-16
Орчуулсан: Сон Ыйминь
2016.01:20